

# Хүйсээ солиулсан хүмүүсийн Сүм дэх оролцоо

ОРОН НУТГИЙН УДИРДАГЧДАД ЗОРИУЛСАН УДИРДАХ ЗАРЧМУУД

Энэхүү баримт бичиг нь “Хүйсээ солиулсан хүмүүс” *Ерөнхий гарын авлагын* 38.6.23-т уг журмыг нэмэлтээр оруулсан болно. Үүний зорилго нь орон нутгийн удирдагчдад Сүм дэх оролцооны тодорхой хэсгүүдийн талаар хувь хүмүүстэй болон тэдний гэр бүлтэй зөвлөлдөхөд нь туслах явдал юм.

## Ерөнхий удирдамж

Бүх тохиолдолд орон нутгийн удирдлагууд:

- Сүнслэг удирдамж хайна.
- Хувь хүмүүс болон тэдний гэр бүлүүдэд сайн мэдээний үнэнийг заахдаа тэднийг хайрлаж, хүндэлж харьцана.
- Хувь хүн болон тойргийн бусад гишүүний хэрэгцээг харгалзан үзнэ.
- Хүйсийн талаарх Сүмийн сургаалыг буруугаар ойлгож, гуйвуулахгүй байхад анхаарна.
- Зөвлөгөө эрэлхийлнэ. Бишоп нь гадасны ерөнхийлөгчтэй зөвлөлдөнө. Гадас, номлолын ерөнхийлөгч нь Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс удирдамж эрэлхийлнэ.
- Насанд хүрээгүй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдыг оролцуулна.

## Дуудагдах нэр болон төлөөний нэр

Сүмийн албан ёсны бүртгэл нь гишүүний төрөлх биологийн хүйсийг тусгасан байдаг.

Дуудагдах нэр болон төлөөний нэр нь хувь хүмүүс болон тэдний гэр бүл, найз нөхөд, Сүмийн гишүүдийн хооронд үлдэх асуудал байх ёстой. Гишүүд хувь хүнийг хэрхэн дуудахыг орон нутгийн удирдагчид тодорхойлж, заах ёсгүй.

Хэрэв гишүүн нь дуудагдах нэртэй бол гишүүнчлэлийн бүртгэл дээрх “Дуудагдах нэр” талбарт тэмдэглэж болно.

## Тодорхой хүйсийн хүмүүст зориулсан цуглаан, үйл ажиллагаа

Хувь хүмүүс төрөлх биологийн хүйстэйгээ нийцсэн, тухайн хүйсийн хүмүүст зориулсан цуглаан, үйл ажиллагаанд оролцдог.

Нэн ховор байх ёстой аливаа онцгой тохиолдолд дээр дурдсан “Ерөнхий удирдамж”-ийг чанд мөрдөж, Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлөөр батлуулна.

## Хоногоор явах үйл ажиллагаа

Тухайн хүйсийн хүмүүст зориулсан хоногоор явах үйл ажиллагаануудад хувь хүмүүс зөвхөн төрөлх биологийн хүйсэд нь нийцсэн аялалд очдог. Ийм үйл ажиллагаануудын жишээнд Залуу эмэгтэйчүүдийн аялал, Аароны санваартны чуулгын аялал орно.

Төрөлх хүйсээ солихоор мэс заслын болон бусад хэлбэрээр төлөвлөж байгаа хувь хүмүүсийг эрэгтэй, эмэгтэйчүүдийн хамтарсан хоногоор явах үйл ажиллагаан дээр хонохыг зөвшөөрдөггүй. Өсвөр үеийнхнийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчийн асрамжид өгөх ба тэд орон байр зохион байгуулах үүрэгтэй. Тухайн хүйсийн хүмүүст зориулагдаагүй үйл ажиллагаануудын жишээнд ганц бие залуучуудын чуулган, Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө чуулган, залуучуудын чуулган орно.

## Дуудлага ба үүрэг даалгавар

Төрөлх хүйсээ солиулахаар мэс заслын болон бусад хэлбэрээр төлөвлөж байгаа хувь хүмүүсийг (1) тодорхой хүйс заасан байгууллагад дуудлага өгөх, (2) багшаар үйлчлэх, (3) хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллах зэрэг үүрэгт ажилд дууддаггүй. Тэд өсөж хөгжих, бусдад үйлчлэх боломж олгох өөр дуудлага эсвэл ажил үүргийг хүлээн авч болно.

## Сүмийн барилга байгууламж дахь бие засах газар

Бие засах газар нь хувийн болон аюулгүй орчныг бүрдүүлсэн байх ёстой. Бүх хүний хувийн нууц, нэр төрийг хүндэтгэхийн тулд анхаарал халамж тавих ёстой.

Төрөлх хүйсээ солихоор мэс заслын болон бусад хэлбэрээр төлөвлөж байгаа хувь хүмүүс боломжтой бол ганц хүн ашиглах бие засах газрыг ашиглах ёстой.

Хэрэв нэг хүний бие засах газар байхгүй бол орон нутгийн удирдагч хувь хүнтэй (мөн өсвөр үеийнхний эцэг эх, асран хамгаалагчидтай) шийдэл олохоор зөвлөлдөнө. Сонголтууд:

- Хувь хүний төрөлх биологийн хүйсэд нийцсэн бие засах газар ашиглах.
- Тухайн хүний хүйсийн дотоод мэдрэмжтэй нь нийцсэн бие засах газар ашиглах. Итгэл даах хүн өөр хүмүүс нэгэн зэрэг бие засах газрыг ашиглахгүй байхад анхаарна.